



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар A/56

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын цацрагийн хамгаалалтын нийгэмлэгт 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хооронд зохион байгуулагдах "Цацрагийн хамгаалалт "О-2" "Х2" сургалт"-д Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албаны ээлжийн техникч С.Баярсайхан, П.Чинбаяр нарыг хамруулсугай.

2. Сургалтын төлбөрт 360,000 (гурван зуун жаран мянга) төгрөгийг зохих журмын дагуу гарган зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтын үр дүнд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн аюулгүй байдал, технологийн алба (Г.Цэвээнгэрэл), Нисэхийн сургалтын төв (Б.Урантөгс)-д, сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн дотор тайлагнахыг суралцагч С.Баярсайхан, П.Чинбаяр нарт тус тус үүрэг болгосугай

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.БАТСАЙХАН

1723 01 0410